



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг.

Бага тойруу 44, Засгийн газрын III байр.

Утас: 26-22-27, Факс: 263727

И-мэйл: info@mes.gov.mn, Веб сайт: www.mes.gov.mn

2021.01.29 № 2/391
танай _____-ны № _____-т

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР З.ДАШДАВАА
ТАНАА**

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн биелэлтийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: 24 хуудастай.

~~ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА~~  ~~Д.БАТБААТАР~~



1421100272

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН
2020 ОНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот

№	Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
1	4.1.1.1. төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх,	Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох.	<p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны дэргэдэх салбар зөвлөлийн нэр дэвшүүлэх тогтоолыг үндэслэн дараах албан тушаалтнуудыг албан тушаал томилж, тушаалыг гардуулж өгөв. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн “нэр дэвшүүлж, албан тушаалд томилох тухай” 156 дугаар тогтоолын дагуу Жадамбын Ганбаатарыг Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны “Жадамбын Ганбаатарыг ажилд томилох тухай” Б/70 дугаар тушаалаар, 2. Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн “нэр дэвшүүлж, албан тушаалд томилох тухай” 158 дугаар тогтоолын дагуу Жадамбын Мягмарыг Сургуулийн өмнөх боловсролын газрын даргын албан тушаалд Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны “Жадамбын Мягмарыг ажилд томилох тухай” Б/71 дугаар тушаалаар, 3. Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн “нэр дэвшүүлж, албан тушаалд томилох тухай” 157 дугаар тогтоолын дагуу Гочоогийн Энхжаргалыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны “Гочоогийн Энхжаргалыг ажилд томилох тухай” Б/73 дугаар тушаалаар, 4. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн “нэр дэвшүүлж, албан тушаалд томилох тухай” 06 дугаар

тогтоолын дагуу Доржгочоогийн Одгэрэлийг Инновацийн хэлтсийн даргын албан тушаалд Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 5 дугаар сарын 13-ний өдрийн Б/72 дугаар тушаалаар,

5. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн “нэр дэвшүүлж, албан тушаалд томилох тухай” 05 дугаар тогтоолын дагуу Төмөрбаатарын Түмэнжаргалыг Суралцагчийн хоол үйлдвэрлэлийн хэлтсийн даргын албан тушаалд Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 5 дугаар сарын 13-ний өдрийн Б/74 дүгээр тушаалаар тус тус томилсон.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны сул орон тоонд төрийн албаны тусгай шалгалт өгч тэнцсэн 8 иргэнийг дараах албан тушаалд томилсон. Үүнд:

1. Мэдээллийн технологи, статистикийн хэлтсийн Салбарын мэдээлэл, технологийн бодлого, зохицуулалт, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтнээр Н.Мөнхсанчир,
2. Мэдээллийн технологи, статистикийн хэлтсийн Боловсролын салбарын статистик, мэдээллийн сан, дүн шинжилгээ хариуцсан шинжээчийн Б.Дэмэдорж,
3. Санхүү, эдийн засгийн газрын Ерөнхий боловсролын төсвийн төлөвлөлт, зохицуулалт хариуцсан мэргэжилтнээр Г.Эрдэнэсүрэн,
4. Санхүү, эдийн засгийн газрын Салбарын хөтөлбөр, арга хэмжээ болон сургуулийн өмнөх боловсролын төсвийн төлөвлөлт, зохицуулалт хариуцсан мэргэжилтнээр М.Балжинням,
5. Ерөнхий боловсролын газрын Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, орчны аюулгүй байдлын стандарт, хэрэгжилтийн асуудал хариуцсан мэргэжилтний П.Наранжаргал,
6. Дээд боловсролын газрын Дээд боловсролын сургалтын хөтөлбөр, чанарын үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтнээр Э.Батсэлэм,

<p>7. Тусгай хэрэгцээт боловсролын хэлтсийн Сургалтын орчин, сурах бичиг, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх асуудал хариуцсан мэргэжилтний Г.Амаржаргал,</p> <p>8. Туршилтын хугацаа дууссан Б.Гэрэлтуяаг тусгай хэрэгцээт боловсролын агуулга, хөтөлбөр, хэрэглэгдэхүүний асуудал хариуцсан мэргэжилтнээр Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 5 дугаар сарын 18-ний өдрийн ажилд томилох тухай тушаалаар тус тус албан тушаалд томилсон.</p>	<p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны харьяа байгууллагын хүний нөөцийн чадхийг сайжруулах, сул орон тоог нөхөх ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Биеийн тамир, спортын газрын дэд дарга, 2. Боловсролын үнэлгээний төвийн захирал, 3. Боловсролын мэдээллийн технологийн төв УТУГ-ын захирал, 4. Улсын Филармонийн захирал, 5. Монголын Театрын музейн захирал, 6. Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргааны даргын сул орон тоонд тусгай шалгалтыг зарласан. <p>Тусгай шалгалтад орсон оролцогч нараас тэнцсэн Ц.Одонбаяр, Ж.Ган-Эрдэнэ, Д.Наранжаргал нарыг томилуулах тухай Салбар зөвлөлийн тогтоолыг сайдад хүргүүлсэн.</p> <p>Төрийн албаны зөвлөл болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны дэргэдэх салбар зөвлөлийн тогтоолыг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none"> 1. Биеийн тамир, спортын газрын дэд даргаар Ц.Одонбаяр 2020 оны Б/43 тоот тушаалаар жинхлэн томилсон, 2. Боловсролын үнэлгээний төвийн захирлаар Ж.Ган-Эрдэнийг 2020 оны Б/51 тоот тушаалаар жинхлэн томилсон,
---	--

			<p>3. Монголын Театрын музейн захирлаар Д.Наранжаргалыг 2020 оны Б/52 тоот Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайдын тушаалаар тус тус жинхлэн томилж харьяа байгууллагын удирдах албан тушаалтны хүний нөөцийн чадхийг сайжруулан ажилласан.</p> <p>Боловсрол, шинжлэх ухааны яамнаас 2020 онд нийт 4 удаагийн тусгай шалгалтыг Төрийн албаны зөвлөлөөс өгсөн зөвлөмжийн дагуу халдвар хамгааллыг сахиж зохион байгуулсан.</p>
2	<p>4.1.1.2.нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан дэвшүүлэх,</p>	<p>Албан тушаалтанд тавигдах ёс зүй, боловсрол, мэдлэг, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх.</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуулийн 8 дахь хэсэгт 2020 оны 7 дугаар сарын 7-ний өдрийн өөрчлөлтийн дагуу Боловсрол, шинжлэх ухааны яамны удирдах алабн тушаалтаны ажлын байрны тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн “Албан тушаалтын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай” 03 дугаар тогтоолын дагуу шинэчлэн Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны “Ажлын байрны нэр, алан тушаалтын тодорхойлолт батлах тухай” 2020 оны В/34, В/35 дугаар тушаалаар тус тус баталсан.</p> <p>Албан тушаалын тодорхойлолтыг батлахдаа яамны үйл ажиллагаанд илэрч байгаа зарим ажлын байрны ажлын ачаалал, чиг үүргийн давхардал, хийдлийг тодорхойлж, албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах чиглэлээр тодорхой санал гарган, ажлын хэсгийн дүгнэлт саналыг үндэслэн ажлын байрны нэр, ангилал зэрэглэлийг шинэчлэн тогтоож, албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан.</p> <p>Албан тушаалын тодорхойлолтын төслийг тус яамны Салбар зөвлөлийн хурлаар хэлэлцэн дүгнэлт гаргаж, зөвшөөрөл авахаар Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн “Боловсрол, шинжлэх ухааны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” 51 дүгээр тогтоолын дагуу 11 газар, 4 хэлтсийн даргын, 92 ажлын</p>

байрны албан тушаалын тодорхойлолтын төслийг боловсруулан Төрийн албаны зөвлөлөөс зөвшөөрсөн авхаар хүргүүлсэн.

Төрийн албаны зөвлөлийн 2020 оны “Зөвшөөрөл олгох тухай” 46 дугаар тогтоолыг үндэслэн Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар ажлын байрны тодорхойлолтыг тус тус батлаж, мөрдөн ажиллаж байна.

Ёс зүйн дүрмийг яамны дотоод сүлжээнд байршуулж, яамны албан хаагчдад танилцуулсан. Тус яамны дэргэдэх Ёс зүйн зөвлөлийг хууль тогтоомжийн дагуу яам, агентлагийн албан хаагчдаас санал авч хамгийн их санал авсан албан хаагчдаар бүрдүүлэн Төрийн албан зөвлөлийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2019 оны “Ёс зүйн зөвлөл байгуулах тухай” 02 дугаар тогтоолоор байгуулсан. Салбар зөвлөлийн 2019 оны “Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” 07 дугаар тогтоолоор Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан.

Яам, агентлагийн удирдлага, албан хаагчдад Төрийн албаны шинэчилсэн хууль, тогтоомж, ёс зүйн шинэ дүрмийн талаар 2020 онд Коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэл, Монгол Улсын Засгийн газар, УОК-ийн шийдвэрийн дугаа сургалт зохион байгууллагагүй ч яамны дотоод сүлжээ болон онлайн хичээлийг 3 удаа зохион байгуулсан.

Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” А/59 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-д нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит

3	4.1.1.7.нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх,	Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх.	<p>зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх зэрэг зүйл, заалтыг тусган оруулсан.</p> <p>Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, балбан бус боловсрол, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм, Ёс зүйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/243 дугаар тушаалаар батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Дээрх журамд боловсролын салбарын ёс зүйн зөвлөл нь аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд байгуулагдан ажиллахаар заасан бөгөөд хэрэгжилтийг тухай зөвлөл хариуцсан ажиллахаар заасан. Иймд салбарын ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаа тус яаманд шууд харьяалагддаггүй.</p> <p>Тус яам нь “Дүрэм батлах тухай” Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг мөрдөн ажиллаж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч, түүний үндэслэлийг шалган тогтоож, дүгнэлт гаргах эрх бүхий байнгын ажиллагаатай, орон тооны бус Ёс зүйн зөвлөлийг Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийн хянан шийдвэрлэх журам”-ын дагуу яамны дэргэдэх ёс зүйн зөвлөлийг байгуулахдаа дотоод сүлжээгээр 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн дотор санал авсан боловч яамны албан хаагчдын оролцооны ирц хангалтгүй байсан тул бичгээр дахин санал авч хамгийн олон санал авсан албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр Яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн 2019 оны 02 дугаар тогтоолоор байгуулсан.</p>
---	--	---	---

Яамны дэргэдэх орон тооны ёс зүйн зөвлөлд 2019 онд 8 гомдол маргаан ирснийг зөвлөл журмын дагуу судлан хэлэлцэж шийдвэр дүгнэлт гаргасан. Эдгээр гомдол маргааны дийлэнх нь тус Ёс зүйн зөвлөлд хамааралгүй асуудал ирснийг холбогдох байгууллагад шилжүүлсэн. 2020 онд Ёс зүйн зөвлөлд гомдол маргаан ирээгүй байна.

Яамны дэргэдэх орон тооны бус зөвлөл нь байгуулагдсанаас хойш яамны албан хаагчдын болон харьяа байгууллагын удирдлага, их дээд сургуулийн багш, оюутнуудын ёс зүйн мэдлэгийг дээшлүүлэх, гадаадад томилолтоор ажиллахдаа ёс зүйн зөрчил гаргахгүй байх зорилгоор дараах ажлуудыг зохион байгуулсан ажилласан. Үүнд:

1. Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах ажлыг үе шаттай зохион байгуулсан. Энэ ажлын хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А/138 дугаар тушаалыг батлан яамны дотоод сүлжээгээр, Төрийн нарийн бичгийн даргын А/226 дугаар тушаал баталж, яамны аппаратын хурал дээр биечлэн танилцуулж, яамны дотоод үйл ажиллагаанд сахилга хариуцлагыг дээшлүүлэхийг удирдах албан тушаалтан болон албан хаагчдад үүрэг болгосон. ЗГ-ын 2018 оны 258, Удирдах ажилтны улсын зөвлөгөөний зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. Хэрэгжилт 96 хувьтай хэрэгжүүлсэн,
2. Гадаадад томилолтоор ажиллах албан хаагчдад ёс зүйн алдаа гаргах байх баталгааг бичгээр дараах байдлаар гаргуулах. Төрийн албаны тухай хуулийн 40.2-т заалт, Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 3.1.4.в, 3.1.4.г дэд заалтыг мөрдлөг болгон дээдлэн ажиллаж, гадаад улсад албан томилолтоор ажиллах хугацаандаа дипломат ёс жаягийг чанд баримталж, Монгол Улсын нэр хүндэд харшилсан

			<p>аливаа үйлдэл гаргахгүй, гадаадад зорчихдоо мөрийтэй тоглоом (казино) тоглож, энэ төрлийн үйлчилгээний газраар үйлчлүүлэхгүй,</p> <p>3. “Төлөвлөлт ба тайлангийн чанарт анхаарах зарим асуудал”, “Төрийн албан хаагчдын үнэт зүйлс ба ёс зүй”, “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал”, “Захиргааны ерөнхий хууль”, “Төрийн албаны тухай хууль”, “Төрийн албаны стандарт, ёс зүй ба манлайлал”, “Төрийн албан хаагчийн ёс зүй” зэрэг сургалтыг цахимаар зохион байгуулж, яамны албан хаагчид, нэгжийн удирдлагуудыг бүрэн хамруулсан,</p> <p>4. Төрийн албаны үнэт зүйл, эрхэмлэн дээдлэх зарчим, үнэлэмж, ёс зүйн хэм хэмжээг өөрийн биеэр үлгэрлэн хэвшүүлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлж, зөрчлийн аливаа илрүүлэх, нэгжийн удирдлагын ажлын гүйцэтгэлийг бодитой үнэлэх, зөрчлийг таслан зогсоох зорилгоор “Хөдөлмөрийн дотоод журам”-д нэмэлт өөрчлөлтийг оруулан батлан, мөрдөн ажиллаж байна. Төрийн албаны үнэт зүйл, эрхэмлэн дээдлэх зарчим, үнэлэмж, ёс зүйн хэм хэмжээг өөрийн биеэр үлгэрлэн хэвшүүлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлж, зөрчлийн аливаа илрүүлэх, нэгжийн удирдлагын ажлын гүйцэтгэлийг бодитой үнэлэх, зөрчлийг таслан зогсоох зорилгоор “Хөдөлмөрийн дотоод журам”-д нэмэлт өөрчлөлтийг оруулан батлан, мөрдөн ажиллаж байна,</p> <p>5. Яамны албан хаагчдыг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахиж ажиллах заалтыг оруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>
4	4.1.1.9.төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл, боломжийг сайжруулах	Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох	Иргэдээс төрийн захиргааны төв байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг улирал тутам өссөн дүнгээр гаргаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж байна. Боловсрол, шинжлэх ухааны яам (цаашид БШУЯ гэх), болон сайдад ажлаа шууд хариуцан тайлагнадаг харьяа

байгууллагуудад энэ оны гуравдугаар улирлын байдлаар нийт 11878 өргөдөл, гомдол, хүсэлт ирүүлсэн байна.

Боловсрол, шинжлэх ухааны салбарт 2020 оны гуравдугаар улиралд 11878 өргөдөл гомдол ирүүлснээс 21.8% нь бичгээр, 19.9% нь цахимаар, 47.1% нь утсаар, 10.1% нь биечлэн уулзсан байна. Нийт 11878 өргөдөл, гомдол ирүүлснийг ангилж үзвэл хүсэлт 10869 буюу 91.50%, санал 570 буюу 4.80%, гомдол 439 буюу 3.70% байна.

Шийдвэрлэлт:

- 2020 оны III улиралд ирүүлсэн 11878 өргөдөл, санал, хүсэлтийн 11808 буюу 99.4 хувийг шийдвэрлэсэн дүнтэй байна. Шийдвэрлэгдээгүй 70 өргөдөл хугацаандаа судлагдаж байна.

- 2020 оны гуравдугаар улиралд иргэдийг хүлээн авах хуваарийн дагуу Сайд 214, дэд Сайд 70, Төрийн нарийн бичгийн дарга 34 иргэн, 15 байгууллагын төлөөллийн санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэлээ.

Цаашид:

- Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг судлан, эрхэлсэн ажлын чиглэлээр боловсруулах хууль тогтоомж, журам, дүрэм болон яамнаас баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаандаа тэдний санал, санаачилгыг тусгахад анхаарна.

- Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэхэд иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн үзүүлэлтийг харгалзан ажиллана.

Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг агуулагаар ангилвал:

1. Дээд боловсролын мэдээллийн системд бүртгүүлэх, Гадаадад их дээд сургуулиудад суралцахад Боловсролын тогтолцооны шилжилтийн тухай тодорхойлолт, Монгол Улсын суурь боловсролын гэрчилгээ болон бүрэн дунд боловсролын үнэмлэх дүйцүүлэх тодорхойлолт, Их, дээд сургуулийн дүн дүйцүүлэх тодорхойлолт хүссэн өргөдөл 55,2 хувь буюу 6556 өргөдөл,

			<p>2. Их, дээд сургуулийн дипломын лавлагаа, ЕБС-д харьяаллын дагуу элсэн суралцах, Сургалтын тэтгэлэгтэй холбоотой асуудлаар болон төрийн сангийн зээлээр гадаад улсын болон тухайн орны Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах, тэтгэлгийн хугацааг сунгуулах, гадаад, дотоодын их, дээд сургуульд элсэн суралцах, шилжин суралцах, буцалтгүй тусламжид хамрагдах, оюутны хөгжлийн зээл, амьжиргааны зардал хүссэн өргөдөл нь 33 хувь 3919 өргөдөл,</p> <p>3. Санхүүгийн дэмжлэг туслалцаа, тэтгэвэр тэтгэмж, цалин хөлсний асуудлаар, шагналын тэмдэг нөхөн авах талаар, дэмжлэг хүссэн зэрэг нийгмийн халамжийн асуудлаар хандсан 8.5 хувь буюу 1009 өргөдөл,</p> <p>4. Архивын Б маяг авах, гэж үрэгдүүлсэн боловсролын баримт бичиг, бусад 3.3 хувь буюу 391 өргөдөл, гомдол ирсэн.</p>
5	4.1.1.10.нийтийн албаны институт албан даван боломжийг сургах бүрдүүлэх	Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах. Үүнд:	<p>Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 3 төрлийн /ХАУСМ, ХАСХОМ, “Ашиг сонирхлын зөрчилөөс хэрхэн сэргийлэх” болон анхаарах асуудлаар гэсэн сэдэвтэй видео шторкийг яамны цахим санд болон харъяа байгууллагын ЭБАТ нараар дамжуулан мэдээллийн цахим санд нь байршуулсан.</p> <p>ХАС, ХОМ, ХАСУМ хэрхэн үнэн зөв мэдүүлэх, албан хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн холбогдох албан тушаалтануудтай 2020 оны ХАСХОМ гаргах ажлын бэлтгэл хангах, анхаарах зүйл, тулгамдаж буй асуудлууд, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгийн хорооны баталсан 2014 оны 20 дугаар тогтоол, мэдүүлэгийн цахим сангийн талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны харъяа байгууллагын 10 ЭБАТ-ыг хамруулан, уулзалтыг зохион байгуулж, санал солилцсон.</p> <p>Яамны нийт албан хаагчдад сургалтын мэдээлэл, гарын авлагыг албаны цахим хаягаар тогтмол хүргэн танилцуулж байна.</p> <p>Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс</p>

			<p>зүйн дүрэм"-ийн "3.1.1.б. хууль зөрчсөн, авлига авсан, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан аливаа үйлдэлтэй эвлэршгүй байж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлэх" ёс зүйн шаардлагыг биелүүлэх, байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээ үзүүлэхдээ ямар нэг ёс зүйн алдаа гаргахгүй байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Төрийн нарийн бичгийн даргаас үүрэг, чиглэлийг нийт албан хаагчдад өгсөн.</p>
6	<p>4.1.2.1.төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх,</p>	<p>Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах.</p>	<p>Боловсрол, шинжлэх ухааны яамнаас 2020 оны 10 дугаар сарын 02-ны өдөр Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн хичээлийн 8 дугаар байранд зохион байгуулсан "Боловсролын салбарын цахим шилжилт" сэдэвт арга Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх, Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Ж.Мөнхбат, Инноваци, цахим бодлогын байнгын хорооны дарга Н.Учрал болон Ерөнхий сайдын нийгмийн бодлогын зөвлөх Я.Төмөрбаатар нар оролцсон.</p> <p>"Боловсролын цахим шилжилт" үзэсгэлэнгийн үеэр ерөнхий боловсролын сургуулиудад сургалтын удирдлагын системийн туршилтыг хэрэгжүүлэх "Ай Ти Си групп", "ЕСМ", "Мексим консалтинг", "Амжилт дотком", "Эй плас интернэйшнл", "Гранд Ай Ти", сурагчийн ирцийн бүртгэл, сурах бичгийн түрээсийн үйлчилгээ, хүүхдийн үдийн цайны хяналт, бүртгэлийн үйлчилгээний туршилтыг хэрэгжүүлэхээр "Гэрэгэ системс", ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдад зориулсан контент бүхий платформ, гар утасны аппликейшн хөгжүүлэх "ТомЁ Эд Тек" зэрэг үндэсний найман компанитай Боловсрол, шинжлэх ухааны яам хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа. Эдгээр компани нийгмийн хариуцлагын хүрээнд цахим технологийн туршилтыг үнэ төлбөргүйгээр нийслэл болон хөдөө орон нутгийн нийт 90 сургууль, цэцэрлэг дээр гурван сарын хугацаанд хэрэгжүүлэх бөгөөд цаашдын үйл ажиллагааны тогтмол, чанартай байдлыг Боловсрол, шинжлэх ухааны яам хариуцан ажиллах юм.</p>

Үзэсгэлэнд төрийн болон хувийн хэвшлийн 10 гаруй байгууллага, аж ахуйн нэгж оролцож, боловсролын салбарт хэрэгжүүлж байгаа цахим технологийн дэвшил, бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх дараах багц мэдээллийг багш, сурган хүмүүжүүлэгч, эцэг эх, сурагч, оюутнуудад зориулан танилцууллаа. Үүнд:

1. Боловсролын салбарын мэдээллийн систем, түүгээр дамжуулан иргэдэд, олон нийт, шийдвэр гаргагч нарт хүргэж буй цахим үйлчилгээ;
2. Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын хяналт, төлөвлөлтийн цахим систем;
3. Уламжлалт сургалтын үйл явцыг мэдээллийн технологитой интеграцчилсан сургалтын удирдлагын систем (Хувийн хэвшил);
4. Элсэлтийн ерөнхий шалгалтын цахим систем (Боловсролын үнэлгээний төв);
5. Их дээд сургууль дээр хэрэгжүүлж буй цахим үйлчилгээ болон сургалтын удирдлагын систем (Их, дээд сургууль).

Салбарын үйл ажиллагаанд цахим, технологи болон инноваци шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг өргөнөөр нэвтрүүлснээр багшийн ажлын ачааллыг бууруулах, үйлчилгээний зардлыг багасгах, хичээл, сургалтын үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх, цаашид боловсролын чанарын ялгааг арилгаж, сайжруулахад чухал ач холбогдолтой юм.

“Боловсролын салбарын мэдээллийн систем”-ийн ажлын хүрээнд Дээд боловсролын салбарт Дээд боловсролын удирдлага мэдээллийн систем /ДБУМС/ нэвтрүүлж, Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын байгууллагын зарим модулийг шинэчлэн, ерөнхий боловсролын сургуулийн түвшинд Боловсролын бичиг баримт хэвлэх систем, цахим журналын системийг шинээр нэвтрүүлсэн бөгөөд боловсролын баримт бичгийн лавлагааг /суурь, бүрэн дунд боловсролын гэрчилгээ, үнэмлэх 2019 оны төгсөлтийн /ГҮЦ/ машинаас олгож эхлүүлсэн бөгөөд

тухай бүрт шинэчлэлтийг хийж үргэлжлүүлэн ажиллуулж байна.

Засгийн газрын 2018 оны "Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх зарим арга хэмжээний тухай" 259 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 4 дүгээрт Их, дээд сургууль, ерөнхий боловсролын сургууль төгсөгчийн лавлагааг цахим хэлбэрт шилжүүлнэ гэж заасан байдаг. Тус ажлын хүрээнд Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайдын 2018 оны А/286 тоот тушаалаар ерөнхий боловсролын сургууль, дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгчдийн баримт тодорхойлолтыг Төрийн үйлчилгээний цахим /ТҮЦ/ машинаас олгох журам, тодорхойлолтын загварыг тус тус баталсан.

Мөн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/156 тоот тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд боловсролын баримт бичиг олгох, дүйцүүлэх журам батлагдсан. Үүний дагуу 2020-2021 хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн боловсролын баримт бичгийг Боловсролын салбарын мэдээллийн системээс хэвлэж Олгосон бөгөөд, лавлагааг системээс вебээр болон гар утсаны аппликешнаар дамжуулан олгодог болоод байна.

Тодорхойлолтын мэдээллийг ХУР системтэй цахим сервисээр солилцох зориулалт бүхий серверийг Үндэсний дата төвд байрлуулан тус төвтэй гэрээ байгуулсны үндсэн дээр 2019 оноос эхлүүлэн суурь боловсролын гэрчилгээ болон бүрэн дунд боловсролын үнэмлэхний тодорхойлолтыг 2019 оны 08 дугаар сараас ТҮЦ машинаас олгож эхлсэн бөгөөд өнөөг хүртэл олгон ажиллаж байна.

Мөн 2016-2018 онд дээд боловсролын сургалтын байгууллагаас төгсөгчиддөө олгосон дипломын мэдээллийн санг бүрдүүлэн Үндэсний дата төвд байрлах өөрийн сервер дээр байрлуулсан. Тус төвөөс ХУР системтэй цахим сервисээр мэдээлэл солилцох хөгжүүлэлтийн ажлыг

			<p>эхлүүлсэн ба 2019 оны 11 дүгээр сараас дээд боловсролын сургалтын байгууллагын дипломын тодорхойлолтыг ТҮЦ машинаас олгож эхлээд байна.</p> <p>Ерөнхий боловсролын сургалтад цахим журнал хөтлөх талаар авах арга хэмжээний тухай Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/499 тоот тушаал батлагдсантай холбоотойгоор боловсролын салбарын мэдээллийн системд зохих хөгжүүлэлтийг хийж ерөнхий боловсролын сургуулийн багш, анги удирдсан багш, сургалтын менежер, удирдлага, цахим журналыг вебээр болон гар утсаны аппликешнаар хөтлөх боломжийг бүрдүүлсэн. Мөн цахим журнал хөтөлж буй ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын эцэг, эх, асран хамгаалагч нь өөрийн хүүхдийн ирц, дүн, хичээлийн явцын талаар дэлгэрэнгүй мэдээлэл, сургуулийн талаар мэдээллийг вебээр болон гар утсаны аппликешнаар авах боломжийг бүрдүүлсэн.</p> <p>Шинээр хөгжүүлсэн болон сайжруулсан модуль, цахим журнал хөтлөх гарын авлагуудыг бэлтгэн видео хичээл хэлбэрээр боловсруулж систем дээр байршууллаа.</p> <p>“Боловсролын цахим шилжилт” арга хэмжээний хүрээнд Монгол Улсын Засгийн хуралдааны тэмдэглэл гаргуулан ажилласан бөгөөд тэмдэглэлд “Боловсролын цахим шилжилт” буюу бүх шатны боловсролын байгууллагуудын хичээл, сургалтын үйл ажиллагаанд сургалтын удирдлагын системийг нэвтрүүлэх, сурагчийн ирцийн бүртгэл, сурах бичгийн түрээсийн үйлчилгээ, хүүхдийн үдийн цайны хяналт, бүх төрлийн бүртгэлийн үйлчилгээ, сургалтын хэрэглэгдэхүүн, цахим контент бүтээх зэрэг боловсролын салбарын бусад үйлчилгээнд цахим технологийг нэвтрүүлэх туршилтын үр дүнг харгалзан цаашид салбарын үйл ажиллагаанд цахим технологийг нэвтрүүлэх төлөвлөлт боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэнд” хариуцан ажиллахаар шийдвэрлэсэн.</p>
7	4.1.2.4.эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн	Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан	2020 оны эхний хагас жилд 5 удаагийн хяналт-шалгалтын зохион байгуулсан. Үүнд:

	<p>нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох,</p>	<p>сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг Цөөрүүлэх.</p>	<p>1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 03 сарын 04-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/114 дугаартай тушаалаар “Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн”-д ажиллаж Шалгалтаар нийт 104,591.9 мянган төгрөгийн 4 зөрчилд 5 зөвлөмжийг хүргүүлсэн. Зөвлөмжийн биелэлт 91,8%,</p> <p>2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/113 дугаартай тушаалаар “Боловсролын үнэлгээний төв”-д ажиллаж Шалгалтаар нийт 395,166.6 мянган төгрөгийн 10 зөрчилд 10 зөвлөмжийг хүргүүлсэн. Зөвлөмжийн биелэлт 100%,</p> <p>3. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/170 тоот тушаалаар “Улсын дуурь бүжгийн эрдмийн театр”-д ажиллаж Шалгалтаар илэрсэн зөрчилд 10,291.0 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт, 108,000.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага тавигдсан. 1,000.0 мянган төгрөгийн акт төлөгдсөн. /Харьяаллын дагуу Соёлын яам руу шилжүүлсэн/</p> <p>4. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн А/188 дугаартай “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалаар “Орхон аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар”-т ажиллаж Шалгалтаар нийт 13,041.9 мянган төгрөгийн 5 зөрчилд 6 зөвлөмжийг хүргүүлсэн. Зөвлөмжийн биелэлт 100%,</p> <p>5. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн А/215 дугаартай тушаал “Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлэг”-т ажиллаж Шалгалтаар нийт 2,680.8 мянган төгрөгийн 4 зөрчилд 8 зөвлөмжийг хүргүүлэн ажилласан.</p>
8	<p>4.1.2.7.төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлэх,</p>	<p>Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх.</p>	
9	<p>4.1.3.2.Төсвийн төлөвлөлтийн үр ашигтай байдал, гүйцэтгэл, зарцуулалтын хөндлөнгийн хяналт, хариуцлагыг дээшлүүлэх,</p>	<p>Эрсдэлтэй гэж үзсэн төсөвт байгууллагын төсвийн зарцуулалтад санхүүгийн хөндлөнгийн хяналт хийх.</p>	<p>2020 оны сүүлийн хагас жилд 10 удаагийн хяналт-шалгалтыг зохион байгуулсан. Үүнд:</p> <p>1. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 08 дугаар сарын 20-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/29</p>

<p>дүгээр тушаалаар “Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургууль”-д ажиллаж Шалгалтаар нийт 14,532.1 мянган төгрөгийн 8 зөрчилд 14 зөвлөмжийг хүргүүлсэн. Зөвлөмжийн биелэлт 92,8%,</p>	<p>2. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн А/30 дугаар тушаалаар “Монгол Улсын Консерватори”-д ажиллаж Шалгалтаар 1,820,9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 163,800.0 мянган төгрөгийн 4 албан шаардлага тавигдаж 8 зөвлөмж хүргүүлсэн. Төлбөрийн актын биелэлт 100%, албан шаардлагын биелэлт 91%,</p> <p>3. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/31 дугаар тушаалаар “Боловсролын зээлийн сан”-д Шалгалтаар нийт 8 зөрчилд 8 зөвлөмжийг хүргүүлсэн. Зөвлөмжийн биелэлт 85%,</p> <p>4. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/60 дугаар тушаалаар “Дорнод их сургууль”-д ажиллаж Шалгалтаар 409,679.7 мянган төгрөгийн 5 зөрчилд 7 зөвлөмжийг хүргүүлсэн. Зөвлөмжийн биелэлт 90%,</p> <p>5. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулж, удирдамж батлах тухай” А/111 дүгээр тушаалаар “Насан туршийн боловсролын үндэсний төв”-д ажиллаж Шалгалтаар 26,308,2 мянган төгрөгийн 8 зөрчилд 100,0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 5,997,4 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 7 зөвлөмжийг хүргүүлсэн. Зөвлөмжийн биелэлтийг 2021 оны 03 дугаар сарын 25-ны дотор ирүүлэхээр үүрэг болгосон,</p> <p>6. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/122 дугаар тушаалаар “Нийслэлийн ерөнхий боловсролын 93 дугаар сургууль”-д ажиллаж Шалгалтаар 81,498,7 мянган төгрөгийн 4 зөрчилд 3 зөвлөмжийг хүргүүлсэн,</p> <p>7. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/143</p>
--	---

10	4.1.3.3. Засгийн газрын сангийн тусгай	Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт,	<p>дугаар тушаалаар ажиллаж “Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцын 2020 оны Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа”-д Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжүүлсэн салбарын төсөл, арга хэмжээнд гүйцэтгэлийн аудит хийж 5 зөвлөмжийг хүргүүлсэн,</p> <p>8. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/160 дугаар тушаалаар “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар хүртээмжийг сайжруулах төсөл”-д ажиллаж “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж 8 зөвлөмжийг хүргүүлсэн,</p> <p>9. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/167 дугаар тушаалаар “Олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын “Шинэ эхлэл” сургууль”-д ажиллаж “Шинэ эхлэл” сургуулийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж 5 зөвлөмжийг хүргүүлсэн,</p> <p>10. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/183 дугаар тушаалаар “Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургууль”-д ажиллаж Тус сургуулийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлж ажилласан. Ажлын хүрээнд 5 зөвлөмжийг хүргүүлсэн бөгөөд биелэлтийг 2021 оны 03 дугаар сарын 31-ний дотор ирүүлэх үүрэг өгсөн.</p> <p>Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллага, нэгжид 2020 онд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтаар нийт 1,331,411.8 мянган төгрөгийн 66 зөрчилд 12,211.9 мянган төгрөгийн 6 төлбөрийн акт, 277,797.4 мянган төгрөгийн 8 албан шаардлага тавигдсан ба нийт 105 зөвлөмжийг хүргүүлж ажиллалаа. Зөвлөмжийн биелэлт 84%-тай байна.</p> <p>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган Боловсрол, шинжлэх ухааны яамны төсвийн ерөнхийлөн</p>
----	--	---	--

<p>санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох,</p>	<p>зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах.</p>	<p>захирагчийн шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийг Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу www.meds.gov.mn/, www.shilendans.gov.mn байршуулан ажилласан.</p> <p>Боловсрол, шинжлэх ухааны салбарын Төсвийн ерөнхийлөн захирагчийн Шилэн дансны мэдээллийн хувьд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасан мэдээлэл буюу Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хуулийн хугацаанд байршуулсан, 2. Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-д заасан мэдээлэл буюу өмнөх оны төсвийн гүйцэтгэл, сар, улирлын төсвийн гүйцэтгэлүүдийг хуулийн хугацаанд нь байршуулан ажилласан, 3. Тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-д заасан мэдээлэл буюу жилийн эцсийн санхүүгийн тайлан болон хагас жилийн тайланг PDF хэлбэрээр Шилэн дансны цахим хуудасд байршуулан ажилласан. Мөн тус хуульд заасан Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг цахимд байршуулан ажилласан. Хуульд заасан бусад мэдээлэлүүдийг цаг тухай бүрт нь Шилэн дансны цахим санд 7 хоног бүр нийтэд мэдээллэх мэдээлэлүүдийг тухай бүрт нь байршуулан ажиллаа. Үүнд: <p>Тайлант хугацаанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээг нийтэд мэдээллэсэн байна.</p> <p>Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа бүх байгууллагын шилэн дансанд байршуулсан мэдээллийг хянаж үзэхэд нийт байршуулах мэдээллээс 20,862 буюу 89 хувийг байршуулсан байна. Үүнээс хугацаандаа байршуулсан 18,069 буюу 86,7 хувь, хугацаа хоцроосон 2,793 буюу 13,4 хувь, огт байршуулаагүй 432 буюу 2,0 хувь мэдээлэл байна.</p>
---	--	---

			<p>Шилэн дансны мэдээлэлд гэрээ байгуулсан эрх бүхий албан тушаалтнууд ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлээ гаргаж хэвшихгүй байгаатай холбоотойгоор Төрийн нарийн бичгийн даргын тушаалын төсөл боловсруулж батлуулсан. Төрийн аудитын шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах, мэдээллүүдийг нөхөж оруулах чиглэлээр Санхүү, эдийн засгийн газартай хамтран хяналт тавьж ажилласан.</p>
11	<p>4.1.7.3.Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх,</p>	<p>Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нээх.</p> <p>Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэх.</p>	<p>Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу Боловсролын зээлийн сан, Шинжлэх ухаан технологийн сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нээн www.meds.gov.mn www.shilendans.gov.mn цахим санд тогтмол байршуулж байна.</p> <p>Боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд бүх шатны боловсролын сургалтын болон мэргэжлийн байгууллага, багш, ажилтан, төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөөс бүрдсэн Ажлын хэсэг байгуулан ажилласан бөгөөд хуулийн төсөлд цахимаар санал авах, салбарын хэмжээний хэлэлцүүлгийг улсын хэмжээнд зохион байгуулж ажиллалаа.</p> <p>Боловсрол, шинжлэх ухааны яамны веб сайтад байршуулсан үзэл баримтлал болон хуулийн төсөлтэй 57654 иргэн хандалт хийн танилцаж, цахимаар 24381, цаасаар 5319, нийт 29700 хүн саналаа ирүүлсэн. Албан бичгээр төрийн 50 байгууллагын 4988 санал, иргэний нийгмийн 14 байгууллагын 331, нийт 5319 санал ирүүлсэн байна.</p> <p>Хуулийн төслийн хэлэлцүүлгийг анх удаа цахимаар нийт боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтан, мэргэжлийн байгууллага, төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагын саналыг авч тусгасан болно. Цахим хэлэлцүүлэгт 21 аймаг, 9 дүүргийн боловсролын байгууллагын</p>

хамт олны төлөөлөл болох 5632 багш, ажилтан, бусад их дээд сургууль, шинжлэх ухааны болон харьяа байгууллагын 505 төлөөлөл, нийт 6137 хүн оролцож саналаа илэрхийллээ.

Монгол Улсад төрийн болон төрийн бус өмчийн 1454 цэцэрлэг, 839 ерөнхий боловсролын сургууль, 88 их, дээд сургуульд нийт 1,075,170 суралцагч суралцаж, 50,043 багш ажиллаж байна. Энэ нь улсын нийт хүн амын 32 хувийг эзэлж байна. Боловсрол эзэмших нь хүний амьдралын туршид явагддаг тасралтгүй үйл явц гэж үзвэл боловсролын асуудал манай орны нийт хүн амд шууд хамааралтай юм.

Ерөнхий боловсролын сургуульд хэрэглэж байгаа I-XII ангийн бүх сурах бичгийг цахим хэлбэрээр www.econtent.edu.mn, www.meds.gov.mn веб хуудсанд байршуулж, хэрэглэгчдэд нээлттэй ашиглуулж байна.

Мөн андройд, ios үйлдлийн системтэй төхөөрөмжөөр сурах бичгийг ашиглах аппликейшн бий болгосон.

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид сурах бичгийг тохиромжтой хэлбэрээр ашиглах боломжийг бий болгох чиглэлээр холбогдох төрийн бус байгууллагуудыг дэмжин хамтран ажиллаж байна.

Харааны бэрхшээлтэй сурагчдад зориулан 1-3 дугаар ангийн сурах бичгийг брайль болон томруулсан үсгээр хослуулан хэвлэх талаар Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо ТББ-тай, Ерөнхий боловсролын сургуулийн I-XII ангийн сурах бичгүүдийг DAISY E-rub хүртээмжит форматад шилжүүлж хараагүй болон харааны бэрхшээлтэй иргэд бусдын адил ашиглах боломжтой болгох талаар “Хараагүй хүмүүсийн инноваци хөгжлийн төв” ТББ-тай хамтран ажиллаж байна.

Шинжлэх ухаан, технологи инновацийн талаар төрөөс баримталж байгаа бодлого, дэлхийн болон Монголын шинжлэх ухаан, техник технологийн сүүлийн үеийн ололт, амжилтыг олон нийтэд өргөн сурталчлах, шинжлэх ухааны салбарт хийгдэж байгаа судалгаа шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэлд түргэн шуурхай нэвтрүүлэх, дэлхийн шинжлэх ухааны төвүүдтэй хамтран ажиллахад тус дөхөм

12	<p>4.1.10.2. боловсролын байгууллага болон гэр бүлээр дамжуулан авлигыг үл тэвчих, шударга иргэнийг төлөвшүүлэх зорилгоор олон талт арга хэмжээ зохион байгуулах, авлигын эсрэг боловсрол олгох агуулгыг бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр, стандартад тусгах,</p>	<p>Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын агуулга, хичээлийн хөтөлбөрт шударга ёсны үзэл, хандлагыг бий болгох, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх асуудлыг тусгах.</p> <p>Их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвийг тусгах</p>	<p>үзүүлэх зорилготой ашгийн бус шинжлэх ухааны сэтгүүлчдийн клуб төрийн бус байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөөний төслийг боловсруулж байна.</p> <p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны “Хөтөлбөр батлах тухай” А/492 дугаар тушаалаар баталсан бага ангийн “Хүн ба нийгэм”, дунд, ахлах ангийн “Нийгэм судлал”, бага, дунд, ахлах ангийн “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрт шударга ёс, авлигын талаарх агуулгыг тусган ерөнхий боловсролын нийт сургуулийн суралцагчид судалж байна. /Хавсралтаар 3 сурах бичиг хүргүүлэв/</p>
		<p>Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөр батлан хэрэгжүүлэх” ажлын хүрээнд Үр дүнд суурилсан боловсролыг хөгжүүлэх бодлого /дээд боловсрол/-ыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/533 дугаар тушаалаар баталсан.</p> <p>Бодлогын баримт бичигт 4 зорилт дэвшүүлсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Үр дүнд суурилсан боловсролын арга зүйн дагуу сургалтын хөтөлбөр боловсруулах үйл ажиллагааг чанаржуулах; 2. Оюутан төвтэй суралцахуйн үйлийг дэмжсэн сургалтын орчин, нөөц бүрдүүлэх, цахим сургалтын технологийн хэрэглээг нэмэгдүүлэх; 3. Их, дээд сургууль, коллежийн профессор, багш нарын мэргэжил, заах арга зүйн чадамжийг дээшлүүлэх; 4. Сургалтын чанар, үр дүнг хэмжих үнэлгээ, чанарын баталгаажуулалтын тогтолцоог хөгжүүлэх зэрэг болно. <p>Энэхүү бодлого (Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/533 тушаал)-ын 4.1.6-д заасны дагуу дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн боловсруулалтад үнэлгээ хийж, санал, дүгнэлт боловсруулах ажлын хэсгийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн А/405 дугаар тушаалаар байгуулан 60 их, дээд сургуулийн 536 бакалаврын хөтөлбөрт</p>	

		<p>үнэлгээ хийж, сургууль бүрт чиглэл, зөвлөмжийг өгсөн. Ажлын хэсгийн 9 багийн тайланд хөтөлбөрийн ерөнхий 10 чиглэлээр дүн шинжилгээ хийн гарсан үр дүнг "CDIO-2019" эрдэм шинжилгээний 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлээд байна.</p> <p>Хүний хөгжлийг хангах чиглэлээр 3 кредитийн "Хүний үндсэн эрх /шударга ёс, авлигаас урьдчилан сэргийлэх/, хувь хүний төлөвшил, хөгжлийн талаар суралцах, бүтээлч сэтгэлгээ, хувийн зохион байгуулалт, өөрийгөө хянах чадвар, багаар ажиллах чадвар, нийгэм, хүмүүнлэгийн үйл ажиллагаанд биечлэн оролцох, зохион байгуулах чадвар эзэмшүүлэх" хичээлийг оруулсан байгаа болно.</p> <p>Дэлхий нийтийг хамарсан "Коронавируст халдвар (COVID-19)ц цар тахлын үед ямар нэгэн заалны болон танхимын сургалтыг бүрэн хийх боломжгүй болсон. Монгол Улсын Засгийн газар, УОК-ийн шийдвэрийн хүрээнд төлөвлөгдсөн ажил бүрэн хийгдээгүй болно.</p>
	<p>Оюутан, сурагч, эцэг, эхийг хамруулсан шударга ёсны сэдэвт өдөрлөг, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах</p>	

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ